

## Цахим банкны үйлчилгээний гэрээ

### Нэг.Ерөнхий зүйл

1.1 Энэхүү "Цахим банк" үйлчилгээг үзүүлэх гэрээ /цаашид "Гэрээ" гэх/-г Монгол Улсын Иргэний хууль, Банкны тухай хууль, Банк, эрх бүхий этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр, тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хууль, тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актуудыг үндэслэн, Нэг талаас Чингэлтэй дүүрэг, 1 дүгээр хороо, Д.Сүхбаатарын талбай 11, Улаанбаатар, 15160 Монгол улс хаягт орших Улаанбаатар хотын банкны \_\_\_\_\_ салбар, нэгж, түүнийг төлөөлж \_\_\_\_\_ албан тушаалтай \_\_\_\_\_ /цаашид "Банк" гэх/, Нөгөө талаас \_\_\_\_\_ хаягт орших \_\_\_\_\_ овогтой \_\_\_\_\_ (регистрын дугаар \_\_\_\_\_) /цаашид "Харилцагч" гэх/,

/цаашид "Банк" болон "Харилцагч" нарыг хамтад нь "Талууд" гэх/ нар харилцан тохиролцож, доорх нөхцөлтэй байгуулав.

1.2 Гэрээний зорилго нь банк харилцагчдад бүтээгдэхүүн, үйлчилгээг шуурхай хүргэх, харилцагчийн банкаар үйлчлүүлэх зардал болон цагийг хэмнэх үүднээс энэхүү гэрээний 1.3.1-1.3.4-д заасан банкны бүтээгдэхүүн, үйлчилгээг үүрэн утас болон интернэтээр дамжуулан үзүүлэхтэй холбогдон үүсэх харилцаа, талуудын эрх, үүргийг зохицуулахад оршино.

1.3 Гэрээнд хэрэглэгдсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

1.3.1 "Цахим банкны үйлчилгээ" гэж харилцагч мобайл, интернэт сувагаар дамжуулан авч буй энэхүү гэрээний 1.3.2, 1.3.3, 1.3.4-д заасан үйлчилгээг;

1.3.2 "Мессеж банк үйлчилгээ" – Банктай хамтран ажиллах гэрээ байгуулсан үүрэн телефоны оператор компанийн хэрэглэгч бөгөөд Харилцагчийн харилцах, төлбөрийн хадгаламж, картын дансны үлдэгдэл, банкны валютын ханш, дансны орлого, зарлага, төлбөрийн картын хүчинтэй хугацаа дуусах талаарх мэдээлэл, хугацаат хадгаламжийн хугацаа дуусах мэдээлэл, зээлийн хуваарьт төлөлийн мэдээлэл, тогтмол шилжүүлэг хийгдсэн тухай мэдээлэл авах, салбар, АТМ-н байршлын мэдээлэл авах, сүүлийн 5 гүйлгээний лавлагаа, тогтмол шилжүүлэг хийхэд дансны үлдэгдэл хүрэлцэхгүй байгаа талаар мэдээлэл авах, улайлтын эрхтэй дебит картын улайлтын ашиглалтын хувь, зээл төлөх хугацааны талаарх мэдээллийг түүний үүрэн утсанд эсвэл цахим хаягт хүлээн авах үйлчилгээ;

1.3.3 "Интернэт банк үйлчилгээ" гэж <https://ebank.ubcbank.mn> вэб хуудсанд нэвтрэн орж авч буй үйлчилгээнээ. Үүнд:

- |  |   |
|--|---|
| 1.3.3.1 Гүйлгээний түүхчилсэн лавлагаа харах;  | 1.3.3.8 Гүйлгээ хийх;   |
| 1.3.3.2 Харилцах, хадгаламжийн дансны лавлагаа харах, хууль хэвлэх;                    | 1.3.3.9 Гадаад гуйвуулгын гүйлгээ хийх;   |
| 1.3.3.3 Валютын ханш харах;  | 1.3.3.10 Багц гүйлгээ хийх;   |
| 1.3.3.4 Зээл, зээлийн хүүгийн төлбөрийн мэдээлэл;                                      | 1.3.3.11 Захиалгат гүйлгээ хийх;  |
| 1.3.3.5 Хугацаатай хадгаламжийн хугацааг сунгах, дансны хүү болон дуусах өдрийг харах; | 1.3.3.12 Хэрэглэгчийн нэр дээр бусад иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн нэхэмжлэхийн дагуу гүйлгээ хийх; |
| 1.3.3.6 Хадгаламж болон зээлийн тооцоолол хийх;  | 1.3.3.13 Банкинд захидал илгээх, банкнаас захидал хүлээн авах;  |
| 1.3.3.7 Хэрэглэгч өөрийн нэвтрэх эрхээ идэвхгүй болгох;                                | 1.3.3.14 Хэрэглээний төлбөр төлөх;  |

1.3.4 "Тогтмол шилжүүлэг" гэж депозит данснаас депозит данс руу харилцагчийн хүсэлтээр тодорхой хугацаанд, тогтмол дүнтээр болон хувиар мөнгө шилжүүлэх үйлчилгээ;

1.4 Интернэт банкны үйлчилгээг UB city bank аппликацийн ашиглан авч болно.

1.5 Мессеж банкны үйлчилгээний хувьд 20 \_\_\_\_\_ оны \_\_\_\_\_ сарын \_\_\_\_\_-ны өдрөөс эхлэн хугацаагүй гэрээ байгуулав.

1.6 Интернэт банк үйлчилгээний хувьд энэхүү гэрээ нь 20 \_\_\_\_\_ оны \_\_\_\_\_-р сарын \_\_\_\_\_-ны өдрөөс 20 \_\_\_\_\_ оны \_\_\_\_\_-р сарын \_\_\_\_\_ өдөр хүртэл 1 жилийн хугацаанд хүчин төгөлдөр үйлчилнэ. Үг үйлчилгээг автоматаар сунгах хүсэлт гаргасан тохиолдолд хүсэлтэд заасан хугацаагаар гэрээний хугацаа сунгагдана.

### Хоёр. Үйлчилгээний нөхцөл

2.1 Харилцагчийн банкны тусгай дугаарт илгээсэн мобайл мессеж, цахим шуудангийн хаяг, интернэт банкны үйлчилгээнд нэвтрэх нэр, нууц үг, гүйлгээний нууц үг нь харилцагчийн банкин дахь мөнгөн хөрөнгийг захиран зарцуулахад хэрэглэгдэх албан ёсны баталгааг тэмдгийн дардас, мөнгөн хөрөнгийг захиран зарцуулах эрх бүхий этгээдийн баталгааг гарын үсгийн маягтын адил хүчин төгөлдөр байна.

2.2 Банк нь харилцагчаас интернэт банк үйлчилгээний жилийн хураамж, гүйлгээний шимтгэл, мессеж банкны шимтгэл, тогтмол шилжүүлэг үйлчилгээний шимтгэлийг "Банкны үйлчилгээний хүү шимтгэлийн ерөнхий нөхцөл"-д заасны дагуу \_\_\_\_\_ тоот данснаас шууд суутган авах бөгөөд уг эрхийг харилцагч энэ гэрээгээр банкинд олгож байна.

2.3 Мессежээр дамжуулж буй мэдээлэл дэх дансны үлдэгдэл нь үйлчилгээний шимтгэл суутгасны дараах дүн байна.

2.4 Мессежээр харилцагчийн дансны мэдээллийг дамжуулах оролдлого хийх үед тухайн дансанд үйлчилгээний шимтгэл төлөхүйц хэмжээний үлдэгдэл байхгүй бол мэдээллийг дамжуулахгүй.

2.5 Мессежээр хүргэх дансны орлого, зарлагын мэдээллийн хувьд банк харилцагчийн сонгоосон дүн болон түүнээс дээш дүнтэй гүйлгээний мэдээллийг харилцагчийн үүрэн утсанд дамжуулав.

2.6 Интернэт банкны үйлчилгээг ашиглан хийж буй банк хоорондын бага дүнтэй гүйлгээний хувьд хүлээн авагч банк нь онлайн горимд ажиллаж буй, хүлээн авагчийн нэр данс зөрүүгүй байгаа тохиолдолд тухай бүр гүйлгээ хийгдэнэ.

2.7 Банк хоорондын их дүнтэй гүйлгээний хувьд ажлын өдрийн 09.00-15.30 цагийн хооронд хийгдсэн гүйлгээ нь тухайн өдөртөө, ажлын болон ажлын бус өдрийн дээрхи цагаас бусад цагт хийсэн гүйлгээ нь дараагийн ажлын өдөрт хийгдэнэ.

2.8 Тогтмол шилжүүлэг хийх өдрүүдэд харилцагчийн дансанд дахь үлдэгдэл хүрэлцэхгүй тохиолдолд шилжүүлгийг гүйцэтгэхгүй.

2.9 Банк нь харилцагчийн цахим банк үйлчилгээг ашиглан нэг удаа хийх нэг удаагийн гүйлгээний дүнд хязгаар тавихгүй бөгөөд харин үйлчилгээний хүсэлтэд заасан харилцагчийн сонгоосон эрхийн бүлгээс хамаарн нэг өдрийн гүйлгээний дүнд хязгаар тогтооно.

2.10 Харилцагчийн бичгээр гаргасан хүсэлтийн дагуу нэг өдөрт хийх гүйлгээний хязгаарыг системийн гүйлгээний дээд хязгаарын хүрээнд нэмэгдүүлж болно.

### Гурав. Банкны эрх, үүрэг

3.1 Банк дараах эрх, үүрэгтэй байна. Үүнд:

3.1.1 Банк харилцагчийн дансны мэдээллийг мессежээр дамжуулах бүртгээ "Банкны үйлчилгээний хүү шимтгэлийн ерөнхий нөхцөл"-д заасны дагуу шимтгэл суутган авах эрхтэй.

3.1.2 Банк харилцагчийн интернэт банк үйлчилгээний жилийн хураамж, гүйлгээний шимтгэлийг "Банкны үйлчилгээний хүү шимтгэлийн ерөнхий нөхцөл"-д заасны дагуу суутган авах эрхтэй.

3.1.3 Интернэт банкны нууц үг мессежээр илгээхээс бусад тохиолдолд мессежээр мэдээлэл дамжуулах оролдлого хийх үед харилцагчийн дансанд үйлчилгээний шимтгэл төлөхүйц хэмжээний үлдэгдэл байхгүй тохиолдолд мэдээллийг дамжуулахгүй байх эрхтэй.

3.1.4 Гэрээгээр хүлээн зүрхээ биелүүлэхийг харилцагчаас шаардах, хэрэв удаа дараа үүргээ зөрчсөн тохиолдолд гэрээг дангаар цуцлах эрхтэй.

3.1.5 Харилцагчид интернэт банк, мессеж банк, тогтмол шилжүүлэг үйлчилгээний талаар үндсэн ойлголт өгч, мэдээлэл заавраар хангах үүрэгтэй.

3.1.6 Харилцагчийн харилцах данс болон гүйлгээний талаарх мэдээллийг Монгол улсын хууль тогтоомжид зааснаас бусад тохиолдолд гуравдагч этгээдэд задруулахгүй нууцлалыг хадгалах үүрэгтэй.

3.1.7 Харилцагчаас гаргасан гомдол, саналыг хүлээн авч түүнийг шийдвэрлэх талаар шуурхай ажиллах үүрэгтэй.

3.1.8 Харилцагч валютын төрлийг сонгож, мөнгө хүлээн авагчийн нэр, дансны дугаар, мөнгөн дүнг буруу хийснээс үүдэн гүйлгээ хийгдсэн тохиолдолд банк хариуцлага хүлээхгүй.

3.1.9 Харилцагч өөрийн гар утас, интернэт банкны нэвтрэх нэр, нууц үг, гүйлгээний нууц үг, цахим шуудангийн хаягийн нууцлалаа алдсан, бусдад ашиглуулснаас үүдэн эрсдэл, хохирлыг банк хариуцахгүй.

### Дөрөв. Харилцагчийн эрх, үүрэг

4.1 Харилцагч дараах эрх, үүрэгтэй байна. Үүнд:

4.1.1 Гүйлгээний баримт, дансны хуульыг банкнаас гаргуулан авах эрхтэй;

4.1.2 Үйлчилгээний эрх сунгах, хаах хүсэлтийг банкинд бичгээр гаргаж шийдвэрлүүлэх эрхтэй;

4.1.3 Үйлчилгээний талаарх гомдол, саналаа гаргах, гэрээ цуцлах талаар банкинд мэдэгдэх;

4.1.4 Гэрээгээр хүлээн зүрхээ биелүүлэхийг банкнаас шаардах эрхтэй;

4.1.5 Харилцагч нь цахим банк үйлчилгээний хүсэлтийг үнэн зөв бөгөөд үүрэгтэй бөгөөд цахим банк үйлчилгээний хүсэлт нь энэхүү гэрээг байгуулах үндэслэл болно.

4.1.6 Харилцагч Цахим банкны нэвтрэх нууц үг, гүйлгээний нууц үгийг бусдад дамжуулахгүй байх үүрэгтэй ба дор дурьдсан нөхцөл үүссэн тохиолдолд банкинд нэн даруй мэдэгдэн холбогдох арга хэмжээг авахуулав. Үүнд:

4.1.6.1 Цахим банкны үйлчилгээнд нэвтрэх нууц үг, гүйлгээний нууц үгээ бусдад алдсан;

4.1.6.2 Бусад этгээд нэвтрэх эрхийг зөвшөөрөлгүйгээр ашиглан цахим банкинд хандалт хийснийг мэдсэн;

4.1.6.3 Нэг удаагийн нууц үг үүсгэгч програм суулгасан эсвэл нууц үг хүлээн авсан гар утсаа алдсан;

4.1.7 Интернэт банкны үйлчилгээнд бүртгүүлсэн харилцагч эрхийн бүлгээс хамаарч 3 төрлийн гүйлгээний нууц үгнээс сонгох бөгөөд түүнийг ашиглан интернэтээр гүйлгээ хийнэ;

### Тав. Хариуцлага

5.1 Харилцагч нь интернэт банкны нэвтрэх нууц үг, гүйлгээний нууц үгээ бусдад шилжүүлсэн, дамжуулсан, өөрийн анхаарал болгоомжгүйгээс болж интернэт банкны бүхий л нууцлалыг алдсанаас үүдэн хохирлыг банк хариуцахгүй.

5.2 Харилцагч нь үүрэн утсаа ил задгай орхисон, утасны дугаараа түр хугацаанд бусдад шилжүүлсэн, дамжуулсан зэргээс үүдэн дансны нууцлал болон интернэт банкны нэвтрэх нэр, нууц үг алдагдсан тохиолдолд үүсэх хохирлыг банк хариуцахгүй.

5.3 Харилцагчийн мэдээлэл өөрчлөгдсөн бөгөөд энэ тухай банкинд мэдэгдээгүй тохиолдолд үүсэх хохирлыг банк хариуцахгүй.

5.4 Харилцах, хадгаламж, картын дансны үлдэгдэл, банкны валютын ханш, дансны орлого, зарлага, картын хүчинтэй хугацаа дуусах талаарх мэдээлэл, хугацаат хадгаламжийн хугацаа дуусах мэдээлэл, зээлийн хуваарьт төлөлийн мэдээлэл, тогтмол шилжүүлэг хийгдсэн тухай мэдээлэл авах, салбар, АТМ-н байршлын мэдээлэл авах, сүүлийн 5 гүйлгээний лавлагаа, тогтмол шилжүүлэг хийхэд дансны үлдэгдэл хүрэлцэхгүй байгаа талаар мэдээлэл авах, улайлтын эрхтэй дебит картын улайлтын ашиглалт, зээл төлөх хугацааны талаарх мэдээллийг дамжуулах үед үүрэн телефоны оператор компанийн сүлжээний ачаалал их байсан, үүрэн утас унтарсан, эвдрсэн, сүлжээнээс гадуур гарсан, үүрэн утасны эрх хаагдсан, дугаараа сольсон болон банкнаас бусад шалтгааны улмаас мэдээлэл дамжуулах боломжгүй болсноос үүдэн гарах хохирлыг банк хариуцахгүй.

5.5 Харилцагч интернэт банкаар үйлчлүүлэхдээ гэрээгээр хүлээн зүрх, тавигдаж байгаа шаардлага, нөхцөл, зааврыг мөрдөөгүйгээс үүдэн гарах хохирлыг банк хариуцахгүй.

### Зургаа. Бусад

6.1 Мессеж банкны хувьд харилцагч үйлчилгээнд бүртгүүлсэн дансуудаа хаалгасан тохиолдолд гэрээ цуцлаланд тооцно.

6.2 Интернэт банкны үйлчилгээний хувьд энэхүү гэрээний 1.6-д заасан хугацаа дууссан бөгөөд харилцагч "Цахим банк үйлчилгээний хүсэлт"-д автоматаар сунгах гэсэн хэсгийг бөглөөгүй, жилийн хураамжаа төлөөгүй тохиолдолд гэрээ цуцлаланд тооцно.

6.3 Банк гэрээний нөхцөлд өөрчлөлт оруулах тохиолдолд харилцагчид хуанлийн 30-аас доошгүй хоногийн өмнө мэдэгдэх бөгөөд заасан хугацаанд харилцагчийн зүгээс өөр санал ирээгүй бол гэрээний өөрчлөлтийг хүчин төгөлдөр болсонд тооцно.

6.4 Гэрээг харилцагчийн хүсэлтээр, мөн гэрээгээр хүлээн зүрх талууд биелүүлэхгүй болон хуульд заасан бусад үндэслэлээр цуцалж болно.

6.5 Гэрээ нь Монгол Улсын хууль тогтоомжийг үндэслэн хийгдсэн бөгөөд түүний дагуу зохицуулагдана. Хуульд өөрөөр заагаагүй бол гэрээний заалтыг нэн тэргүүнд баримтлана.

6.6 Харилцагч нь энэхүү үйлчилгээгтэй холбоотой аливаа төрлийн гомдлыг утсаар, цахимаар, бичгээр болон биечлэн ирж гаргаж болох бөгөөд банк нь тус гомдлыг хянан үзэж, 30 хүртэлх хоногт багтаан шийдвэрлээд зохих хариуг гомдол гаргагчид мэдэгдэнэ.

6.7 Гэрээний үүргийн биелэлтийн явцад маргаан гарсан тохиолдолд талууд харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэх бөгөөд зөвшилцөлд хүрч чадаагүй тохиолдолд маргааныг Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу шүүхэд хандаж шийдвэрлүүлнэ.

6.8 Гэрээнд талууд гарын үсэг зурж, тамга дарснаар хүчин төгөлдөр болно.

### ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Улаанбаатар хотын банкний төлөөлж:

\_\_\_\_\_/\_\_\_\_\_/\_\_\_\_\_  
Овог, нэр \_\_\_\_\_ Гарын үсэг \_\_\_\_\_

Харилцагч:

\_\_\_\_\_/\_\_\_\_\_/\_\_\_\_\_  
Овог, нэр \_\_\_\_\_ Гарын үсэг \_\_\_\_\_

\_\_\_\_\_ оны \_\_\_\_\_ сарын \_\_\_\_\_-ны өдөр